



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12-дөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 168,000,000.00 (нэг зуун жаран найман сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг, Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын дарга Н.Эрдэнэ-Очир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, Говь-Алтай аймгийн өмчид бүртгэх, эзэмшүүлэх (Говь-Алтай аймгийн Цагдаагийн газарт) ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА  
ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ  
Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны ...1 дүгээр сарын 12-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтанд орсон	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Ланд крузер 200, 02-09УНУ, JTMHX05J204022266	2012/2013	168,000,000.00
Нийт дүн			168,000,000.00
(нэг зуун жаран найман сая)			